



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/217/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



1. Аудитын дүгнэлт



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.23 № 01/22
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.НЭРГҮЙ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,773,793.00	115,359,499.47
33	АВЛАГА	42,283,243.00	33,294,139.47
33300	Татаас, санхүүжилтийн авлага	42,283,243.00	32,796,682.37
335	Бусад авлага	00.00	497,457.10
3351	Байгууллагаас авах авлага	00.00	497,457.10
35	БАРАА МАТЕРИАЛ	19,490,550.00	82,065,360.00
351	Түүхий эд материал	00.00	30,069,710.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	30,069,710.00
354	Хангамжийн материал	19,490,550.00	51,995,650.00
35410	Бичиг хэргийн материал	1,716,600.00	1,774,100.00
35420	Аж ахуйн материал	12,704,450.00	43,176,050.00
35430	Сэлбэг хэрэгсэл	75,000.00	75,000.00
35450	Барилгын засварын материал	836,200.00	2,892,500.00
35470	Бусад хангамжийн материал	4,158,300.00	4,078,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,659,672,822.27	24,385,695,909.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,659,672,822.27	24,385,695,909.73
392	Биет хөрөнгө	15,445,612,822.11	22,224,312,201.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,695,980,092.51	1,695,980,092.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-155,213,385.29	-207,326,298.17
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,350,000.00	64,450,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-56,402,083.33	-47,243,750.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,502,224.00	241,165,251.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-107,906,708.28	-45,790,938.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	91,584,832.00	82,806,782.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,412,754.10	-26,932,309.58
39209	Зам, гүүрийн байгууламж	9,521,939,094.18	17,846,871,069.11
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,859,106,672.91	-3,181,622,468.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,202,848,338.72	7,552,122,019.42
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,331,225,015.39	-1,982,842,108.31
39217	Ном	232,674,860.00	232,674,860.00
393	Биет бус хөрөнгө	214,060,000.16	2,161,383,708.54
39301	Програм хангамж	1,075,000.00	137,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,075,000.00	-3,819.44
39303	Бусад биет бус хөрөнгө	239,490,000.00	2,192,506,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-25,429,999.84	-31,255,972.02
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,721,446,615.27	24,501,055,409.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,241,749.99	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,241,749.99	00.00
413	Өглөг	6,241,749.99	00.00
4136	Бусад өглөг	6,241,749.99	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	6,241,749.99	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	15,715,204,865.28	24,501,055,409.20
51	Засгийн газрын хувь оролцоо	15,715,204,865.28	24,501,055,409.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	641,522,898.45	2,594,753,898.45
51101	Өмч: - төрийн	452,462,898.45	452,462,898.45
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	189,060,000.00	2,142,291,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	14,697,391,238.16	21,530,010,782.08
51210	Өмнөх үеийн үр дүн	14,697,391,238.16	14,697,391,238.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	6,832,619,543.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	376,290,728.67	376,290,728.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,721,446,615.27	24,501,055,409.20



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,269,404,312.57	10,737,183,701.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,122,644,007.04	9,337,843,854.73
120	Нийтлэг татварын бус орлого	2,122,644,007.04	9,337,843,854.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,122,644,007.04	9,337,843,854.73
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,081,800.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,121,562,207.04	9,337,843,854.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,146,760,305.53	1,399,339,846.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,254,253.00	242,143,846.36
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,345,000.00	158,746,001.36
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	40,356,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,984,210.00	13,536,847.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,925,043.00	29,504,998.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,076,506,052.53	1,157,196,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,076,506,052.53	1,157,196,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,776,580,790.34	3,506,407,744.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,776,580,790.34	3,506,407,744.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,736,394,282.34	3,432,999,849.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	633,493,753.90	630,347,857.96
210101	Үндсэн цалин	495,992,776.90	503,780,763.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,556,977.00	59,595,999.80
210104	Урамшуулал	70,464,000.00	66,971,094.41
210105	Гэрээт ажлын хөлс	8,480,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,775,064.85	85,522,728.46
210201	Тэтгэврийн даатгал	57,248,815.66	60,820,048.17
210202	Тэтгэмжийн даатгал	5,677,508.77	6,320,858.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,855,256.17	5,056,667.32
210204	Ажилгүйдлийн даатгал	1,167,869.80	1,211,505.06
210205	Эрүүл мэндийн даатгал	11,825,614.45	12,113,649.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,153,519.78	100,249,338.02
210301	Гэрэл, цахилгаан	8,440,788.78	4,632,247.37
210302	Түлш, халаалт	58,883,298.00	91,098,924.92
210303	Цэвэр, бохир ус	2,829,433.00	4,518,165.73
2104	Хангамж, бараа материалын зардал	82,616,950.00	80,512,199.94
210401	Бичиг хэрэг	12,699,900.00	14,356,100.00
210402	Тээвэр, шатахуун	19,662,180.00	18,443,939.17
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,500,164.00	5,132,730.77
210404	Ном, хэвлэл	36,799,600.00	1,079,430.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	31,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,955,106.00	10,000,000.00
2105	Нормативт зардал	00.00	2,150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,854,525.00	38,099,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	160,000.00	00.00
210604	Урсгал засвар	15,694,525.00	38,099,700.00
2107	Томилолт, зочны зардал	10,797,000.00	2,601,400.00



210702	Дотоод албан томилолт	1,768,000.00	2,346,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,029,000.00	255,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,307,375.00	178,967,132.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,521,067.00	177,820,652.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	148,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285,808.00	183,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,500.00	682,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,744,396,093.81	2,314,549,493.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,709,347.00	168,322,638.88
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,852,000.00	2,930,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,659,834,746.81	2,143,296,504.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,186,508.00	73,407,894.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,186,508.00	29,394,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,506,508.00	18,447,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,680,000.00	10,947,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	44,013,194.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	44,013,194.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	492,823,522.23	7,230,775,956.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	94,353,240.00	398,156,412.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	94,353,240.00	398,156,412.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-94,353,240.00	-398,156,412.80
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	398,470,282.23	6,832,619,543.92

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	641,522,898.45	376,290,728.67	14,697,391,238.16	15,715,204,865.28
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	641,522,898.45	376,290,728.67	14,697,391,238.16	15,715,204,865.28
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	1,953,231,000.00	00.00	00.00	1,953,231,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,832,619,543.92	6,832,619,543.92
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,594,753,898.45	376,290,728.67	21,530,010,782.08	24,501,055,409.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,231,044,294.00	1,441,623,089.36



12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,081,800.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,081,800.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,081,800.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,081,800.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,229,962,494.00	1,441,623,089.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,101,794.00	284,427,089.36
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,345,000.00	158,746,001.36
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	40,356,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,984,210.00	13,536,847.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,772,584.00	71,788,241.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,157,860,700.00	1,157,196,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,157,860,700.00	1,157,196,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,227,369,894.00	1,429,239,189.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,227,369,894.00	1,429,239,189.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,061,355,495.53	1,323,034,612.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	633,493,753.90	630,347,857.95
210101	Үндсэн цалин	495,992,776.90	503,780,763.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,556,977.00	59,595,999.80
210104	Урамшуулал	70,464,000.00	66,971,094.41
210105	Гэрээт ажлын хөлс	8,480,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,775,064.85	85,522,728.46
210201	Тэтгэврийн даатгал	57,248,815.66	60,820,048.17
210202	Тэтгэмжийн даатгал	5,677,508.77	6,320,858.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,855,256.17	5,056,667.32
210204	Ажилгүйдлийн даатгал	1,167,869.80	1,211,505.06
210205	Эрүүл мэндийн даатгал	11,825,614.45	12,113,649.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,153,519.78	100,746,795.12
210301	Гэрэл, цахилгаан	8,440,788.78	4,632,247.37
210302	Түлш, халаалт	58,883,298.00	91,098,924.92
210303	Цэвэр, бохир ус	2,829,433.00	5,015,622.83
2104	Хангамж, бараа материалын зардал	83,030,064.00	79,068,965.77
210401	Бичиг хэрэг	12,638,000.00	12,820,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,662,000.00	18,443,205.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,500,164.00	5,132,730.77
210404	Ном, хэвлэл	37,199,600.00	1,173,030.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	31,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,030,300.00	10,000,000.00
2105	Нормативт зардал	2,420,000.00	2,150,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,420,000.00	2,150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,701,225.00	37,499,700.00
210604	Урсгал засвар	8,701,225.00	37,499,700.00
2107	Томилолт, зочны зардал	6,052,200.00	7,346,200.00
210702	Дотоод албан томилолт	1,768,000.00	2,346,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,284,200.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100,636,650.00	175,675,650.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,650,342.00	174,474,170.99
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	148,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	285,808.00	183,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,500.00	737,000.00



2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,093,018.00	204,676,714.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,241,018.00	201,746,364.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,852,000.00	2,930,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	166,014,398.47	106,204,577.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,376,508.00	29,394,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,506,508.00	18,447,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,870,000.00	10,947,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	123,637,890.47	76,809,877.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,637,890.47	76,809,877.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,675,900.00	12,383,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,675,900.00	12,383,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,675,900.00	12,383,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,675,900.00	12,383,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,675,900.00	12,383,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,675,900.00	-12,383,900.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,157,196,100.0	1,113,182,805.4	44,013,294.7	96.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,157,196,100.0	1,113,182,805.4	44,013,294.7	96.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,127,749,100.0	1,083,788,105.4	43,960,994.7	96.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	652,719,100.0	630,347,858.0	22,371,242.1	96.6
210101	Үндсэн цалин	522,375,100.0	503,780,763.7	18,594,336.3	96.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,784,000.0	59,595,999.8	188,000.2	
210104	Урамшуулал	70,560,000.0	66,971,094.4	3,588,905.6	94.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,213,500.0	85,522,728.5	2,690,771.5	96.9
210201	Тэтгэврийн даатгал	62,892,700.0	60,820,048.2	2,072,651.8	96.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,330,200.0	6,320,858.6	9,341.4	99.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,064,100.0	5,056,667.3	7,432.7	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,266,100.0	1,211,505.1	54,594.9	95.7
210205	Эрүүл мэндийн даатгал	12,660,400.0	12,113,649.3	546,750.7	95.7



2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,747,900.0	100,746,795.1	12,001,104.9	89.4
210301	Гэрэл, цахилгаан	10,000,000.0	4,632,247.4	5,367,752.6	46.3
210302	Түлш, халаалт	95,747,900.0	91,098,924.9	4,648,975.1	95.1
210303	Цэвэр, бохир ус	7,000,000.0	5,015,622.8	1,984,377.2	-28.3
2104	Хангамж, бараа материалын зардал	47,003,900.0	46,305,760.8	698,139.2	98.5
210401	Бичиг хэрэг	12,000,000.0	12,000,000.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	18,000,000.0	18,000,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,803,900.0	5,132,730.8	671,169.2	88.4
210404	Ном, хэвлэл	1,200,000.0	1,173,030.0	26,970.0	97.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,000.0	10,000,000.0	00.0	100.0
2105	Нормативт зардал	2,500,000.0	2,150,000.0	350,000.0	86.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.0	2,150,000.0	350,000.0	86.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,000,000.0	44,970,600.0	29,400.0	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,500,000.0	7,470,900.0	29,100.0	99.6
210604	Урсгал засвар	37,500,000.0	37,499,700.0	300.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	8,000,000.0	7,346,200.0	653,800.0	91.8
210702	Дотоод албан томилолт	3,000,000.0	2,346,200.0	653,800.0	78.2
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.0	5,000,000.0	00.0	00.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,856,200.0	62,644,249.0	3,211,951.0	95.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,776,200.0	61,442,769.0	2,333,431.0	96.3
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.0	148,500.0	351,500.0	29.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	420,000.0	183,980.0	236,020.0	43.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	160,000.0	132,000.0	28,000.0	82.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.0	737,000.0	263,000.0	73.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,708,500.0	103,753,914.1	1,954,586.0	98.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,708,500.0	100,823,564.1	1,884,936.0	98.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.0	2,930,350.0	69,650.0	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,447,000.0	29,394,700.0	52,300.0	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,447,000.0	29,394,700.0	52,300.0	99.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,447,000.0	18,447,000.0	00.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,000,000.0	10,947,700.0	52,300.0	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,157,196,000.0	1,113,182,805.4	44,013,194.7	96.2



1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,157,196,000.0	00.0	1,157,196,000.0	
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,157,196,000.0	00.0	1,157,196,000.0	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,157,196,000.0	1,113,182,805.4	44,013,194.7	96.2
132001	Орон нутгийн төсвөөс	1,157,196,000.0	1,113,182,805.4	44,013,194.7	96.2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	46.00	46.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	17.00	17.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	284,427,089.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,427,089.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	284,427,089.36
2104	Хангамж, бараа материалын зардал	32,763,205.00
210401	Бичиг хэрэг	820,000.00
210402	Тээвэр, шатахуун	443,205.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,487,901.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,487,901.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,379,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,379,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,796,682.37
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	32,796,682.37
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	284,427,089.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	284,427,089.36
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	158,746,001.36
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,356,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,536,847.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	71,788,241.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад



чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Мөрөн сумын Засаг даргын Тамгын газартай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг сумын Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 43-р тогтоол, "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2.857.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 57.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 45.7 сая төгрөгөөр тогтоосон.



Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,779.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө, дансны өглөг данс үлдэгдэлгүй байна.

Үзүүлэлт	/Сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	42.3	33.3	-09.0
Бараа материал	19.5	82.1	62.6
Биет хөрөнгө	15,445.6	22,224.3	6,778.7
Биет бус хөрөнгө	214.1	2,161.4	1,947.3
Нийт хөрөнгө	15,721.4	24,501.1	8,779.6
Дансны өглөг	06.2	00.0	-06.2
Засгийн газрын хувь оролцоо	15,715.2	24,501.1	8,785.9
Хуримтлагдсан үр дүн	14,697.4	21,530.0	6,832.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,721.4	24,501.1	8,779.6

Авлага дансны үлдэгдэл 33.3 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82.1 сая төгрөг болж өмнөх оноос 62.6 сая төгрөгөөр өссөн, биет хөрөнгийн дүн 22,224.3 сая төгрөг болж 6,778.7 сая төгрөгөөр өссөн нь Мөрөн суманд 9.8 км замыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж хүлээн авсан, биет бус хөрөнгө 2,161.4 сая төгрөг болж 1,947.3 сая төгрөгөөр өссөн нь газар эзэмших эрх нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо данс 24501.1 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 21,530.0 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 376,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 10,737.2 сая төгрөг, нийт зардал 3,506.4 сая төгрөг тайлант үеийн үр дүн 6,832.6 сая төгрөг байна. Нийт орлогын дүнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн 8,152.0 сая төгрөгийн зам хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрсөн, зарим хөрөнгийг дахин үнэлж бүртгэсэн 106.2 сая төгрөг материаллаг хэмжээгээр нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант хугацааны үр дүн 20.1 сая төгрөгөөр нөлөөлж нийт цэвэр өмчийн дүн 22,547.8 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсвийн төслийг 1,187.5 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02 тоот тогтоолоор 1,022.7 сая төгрөгөөр анх баталж, Сумын ИТХ-ын 2021 оны 9 сарын 24-ний өдрийн 02 тогтоолоор төсөвт тодотгол хийж 134.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,157.2 сая төгрөгийн төсөв баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд 1,157.2 сая төгрөг батлагдсанаас орон нутгийн төсвөөс 1,157.2 сая төгрөгийн санхүүжилт авч, 1,113.2 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж 44.0 сая төгрөг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 284.4 сая төгрөг хүлээн авснаас 40.4 сая төгрөг өмнөх оны татаас санхүүжилтийн авлага, аймгийн Засаг даргын нөөц сангаас 13.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 31.5 сая төгрөг, Герман улсаас KCS-058-BARUTH/MARK-2020 төслөөс 158.7 сая төгрөгийн хандив хүлээн авч 251.3 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 32.8 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Сангийн яамны зөвшөөрлөөр Герман улсаас KCS-058-BARUTH/MARK-2020 төслөөс 158.7 сая төгрөгийн хандивын санхүүжилт авсан байна.

Корона вирусээс урьдчилан сэргийлэх, эргүүл хяналт хийх, өвчлөлтэй тэмцэхэд Герман улсаас KCS-058-BARUTH/MARK-2020 төслийн хөрөнгө болон орон нутгийн нөөц хөрөнгөөр сумын шуурхай штабын шийдвэр хэрэгжүүлэх, халдвар хамгааллын хэрэгсэл харьяа байгууллага, иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэхэд 204.5 сая төгрөг зарцуулсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 44.0 сая төгрөгийн хэмнэлт гаргасан явдал байна. Үүнд: Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 22.4 сая төгрөг, НДШ-ээс 2.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой 12.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 3,214.9 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 3,506.4 сая төгрөгийн 65 мэдээллээс 3,367.6 сая төгрөгийн 57 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 38.8 сая төгрөгийн 8 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим хуулийн нийцлийн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг хянан үзлээ. Үүнд:

- Мэдээллийн 5 газартай гэрээ байгуулж 8.0 сая төгрөг зарцуулсан байна. Төрийн байгууллагын цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл, шийдвэрийг олон нийтэд сурталчлан таниулахдаа төрийн байгууллагын мэдээллийн суваг, сайтыг ашиглаж төсвийн хөрөнгийн хэмнэлт гаргах нь зүйтэй гэж үзлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснийг аудитаар дахин хянахад хэрэгжилт 90 хувьтай хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын 2021 онд татан төвлөрүүлсэн 32.8 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагын буцаан олголтын мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг анхаарч үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 52.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 52.2 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Төсвийн хэмнэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар:**

1.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1. “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй 11.9 сая төгрөгийн төсөв зарцуулсан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай”-ыг хэрэгжүүлж ажиллах.

2. **Тооцооны үлдэгдэлтэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд цэвэр, бохир усны тооцооны 0.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн тооцооны зөрүү 1.0 сая төгрөг байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар



зүйлийн 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Харилцагч талуудтай хийх тооцоог тухай бүр хийж тооцооны үлдэгдэлгүй ажиллаж хэвших.

3. **Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой**

3.1. Илрүүлэлт:

Шилэн данс цахим хуудсанд 38.8 сая төгрөгийн 8 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.”Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.”Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”-д заасан мэдээллийг тухай бүр нэгдсэн системд мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 20 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар	3	52.2							3	52.2